Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
135 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- [x] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- [ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:
Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:
Байгаль хамгаалагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Туслах түшмэл, ТЗ-2

Ажлын цаг:
Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:
Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг

Хөдөлмөрийн нөхцөл:
Хэвийн

Онцгой нөхцөл:
Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж, байгаль орныг хамгаалах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, байгаль орчноо хамгаалах дадал, хэвшлийг төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Байгаль орчны салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тайлагнах.
2. Байгаль орчны ажиглалт судалгаа хийх, нөхөрлөлд дэмжлэг үзүүлэх, байгалийн баялгийг ашиглахад хяналт тавих, иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалт ухуулга хийх.
3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх –Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Байгаль орчны салбарын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах; 2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах; 3. Хяналт, шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, сорьц, дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх; 4. Байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед шаардлагатай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх.	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г Г, Х Г, Х Г

2 дугаар зорилтын хүрээнд	1. Байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах;	Байгаль, экологид үүсэх сөрөг нөлөөг бууруулсан байна.	Г
	2. Хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;		Г
	3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, хяналт тавих;		Г, Х
	4. Байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;		Г
	5. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан даруйд зохих шатны Засаг даргад мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээ авах;		Г
	6. Байгалийн баялгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах;		Г
	7. Нөхөрлөлүүдийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;		Г
	8. Уул, ой модонд бүгсэн оргодол яллагдагч, ялтныг эрэн сурвалжилж байгаа цагдаагийн албанд газар орны онцлог, байгалийн тогтоц, байршлын талаар мэдээлэл өгөх, газарчлах, хамтран ажиллах;		Г
	9. Байгаль орчны ажиглалт судалгааг тогтмол хийж мэдээг мэдээллийн санд тусгуулах;		Г, Х
	10. Цөлжилт, газрын доройтолд орсон нутгийн судалгаа гаргаж холбогдох газруудад мэдээлэх;		Г
	11. Ойн хөнөөлт шавьж, бэлчээрийн хортон, мэрэгчдийн талаар судалгаа гаргаж холбогдох газруудад мэдээлэх;		Г
	12. Ховор ан амьтдын тархац байршил өсөлтөд байнгын ажиглалт судалгаа хийж, нутгийн иргэдтэй хамтран биотехникийн арга хэмжээ авах.		Г
	1. Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын	Ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажилласан байна.	Г

3 дугаар зорилтын хүрээнд	хөдөлмөрийн дотоод журмыг чанд баримталж, хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргээ шударгаар хэрэгжүүлэх;		
	2. Хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн үйлчилгээг соёлтой, шуурхай хүргэх;	Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.	Г
	3. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;	Журам, заавар, стандартыг мөрдөн ажилласан байна.	Г
	4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх;	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна.	Г
	5. Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх;		Г
	6. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой.	
Мэргэжил	Бүрэн дунд боловсролтой бол мэргэжил шаардахгүй.	
Мэргэшил	Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр мэргэшсэн бол давуу тал болно.	
Туршлага	-	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог хангах; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - иргэдийн санал, бодлыг сонсох, зөв хандлагыг дэмжих, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;

		- багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;
	Бусад	- албан үүргээ хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - байгаль орчноо хамгаалах үзэл санааг иргэдэд тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - мэдээллийг түргэн шуурхай хүргэх, мэдээлэл солилцох; - компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - Харилцааны соёлтой байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Байхгүй.	Бусад харилцах субъект - Сумын ИТХурал, Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан, - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох албан тушаалтан, - Сум, багийн Засаг дарга, - Байгаль хамгаалах нөхөрлөл, мэргэжлийн байгууллагууд, - Төрийн болон төрийн бус байгууллага - Иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ-ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЗОЛЗАЯА 2019оны.10.дугаар сарын 30.-ны өдөр	Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: ..... Дугаар: .....

19 10 30

195

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2019.11.14

Дугаар: А/24

(тамга/тэмдэг)

ДАРГА Т.АРИУНБОЛД

2019 оны 11 дугаар сарын 14-ны өдөр